



# MOORE

## Мөнгө Угаалт Терроризмыг Санхүүжүүлэхтэй Тэмцэхэд бидний оролцоо

Нягтлан бодогчид болон санхүүгийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нар

Эрсдэлээс өөрсдийгөө хамгаалахын тулд юу хийж болох вэ?

Сэжигтэй гүйлгээг мэдээлэх



### ЯМАР ТОХИОЛДОЛД ХУУЛИЙН ДАГУУ ҮҮРЭГ ХҮЛЭЭХ ВЭ?

Харилцагчийн нэрийн өмнөөс дараах ажиллагааг хийсэн бол

- а. үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах;
- б. харилцагчийн хөрөнгийг удирдах;
- в. банкны, хадгаламжийн, үнэт цаасны дансыг удирдах;
- г. компанийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдахад зориулан хөрөнгө татах, бүрдүүлэхийг зохион байгуулах;
- д. хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдах, эсхүл хэлцлийн үндсэн дээр аливаа тодорхой үйл ажиллагаа явуулах, удирдах, эсхүл аж ахуйн нэгжийг худалдах, худалдан авах.



### ЮУГ МЭДЭЭЛЭХ ВЭ?

20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.

Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.



Харилцагчаа таньж мэдэх



### ХАРИЛЦАГЧАА ЯАЖ ТАНЬЖ МЭДЭХ ВЭ?



1. Эцсийн өмчлөгчийг тогтоох
2. НҮБ-ын хориг арга хэмжээнд орсон байгууллага, хувь хүн эсэх?
3. Улс төрд нөлөө бүхий этгээд мөн эсэх?
4. Газар зүйн байршлаас хамаарах эрсдэл тодорхойлох
5. Бүтээгдэхүүн үйлчилгээг үй олноор хөнөөх зэвсэг үйлдвэрлэхээд ашиглаж болох эсэх?



### ЦААШ УНШИХ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль

НҮБ-ийн хориг арга хэмжээний жагсаалт болон дотоодын жагсаалт

ФАТФ Нягтлан бодогчдод зориулсан эрсдэлд суурилсан хандлага гарын авлага

Энэхүү материалыг зөвхөн ерөнхий мэдээлэл олгох зорилгоор бэлтгэсэн бөгөөд нягтлан бодох бүртгэл, татвар болон бусад мэргэжлийн зөвлөх үйлчилгээ өгөх зорилго агуулаагүй учир уг материалд найдан гаргасан шийдвэр, үйлдэл болон үр дагаварт Мүүрь Аудит ХХК хариуцлага хүлээхгүй болохыг мэдэгдэж байна. Тухайлсан зөвлөгөө авахын тулд мэргэжлийн зөвлөхүүдэд хандана уу.